



НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2012 оны
06-р сар

Нийгмийн даатгалын санд 2012 оны 6-р сарын 30-нү байдлаар нийт 353.9 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 121.1 хувиар биелүүлсэн байна. Даатгалын сангуудаас давхардсан тоогоор 1989.1 мянган иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний зардалд нийт 404.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Улсын төсвөөс 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн болон цэргийн тэтгэвэрт 123.8 тэрбум төгрөгийг тэтгэврийн даатгалын санд шилжүүлжээ.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ӨАЙЭАААЭӨ

2012 оны 6-р сарын мэдээгээр нийгмийн даатгалд:

- 27.1 мянган аж ахуйн нэгж байгууллага,
- 585.7 мянган заавал даатгуулагч,
- 72.5 мянган сайн дурын даатгуулагч,
- эрүүл мэндийн даатгалд 1560.2 мянган даатгуулагч шимтгэл төлсөн байна.

НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын таван төрлийн санд энэ оны 6-р сард 77.3 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.3 тэрбум төгрөгөөр өсчээ.


Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 64 % буюу 49.9 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 4% буюу 3.6 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 8 % буюу 6.0 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 4 % буюу 3.3 тэрбум төгрөг;
- Эрүүл мэндийн даатгалын санд 20% буюу 14.4 тэрбум төгрөг.


НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2012 оны 6-р сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 99.0 тэрбум төгрөг зарцуулжээ. 2012 оны 6-р сард тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 99.0 тэрбум төгрөг зарцуулжээ. 2012 оны 6-р сард тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 99.0 тэрбум төгрөг зарцуулжээ.


Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /Тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын сангийн орлого /Тэрбум төгрөгөөр/



Нийгмийн даатгалын сангийн зарлага /Тэрбум төгрөгөөр/



Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 49.9 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагч 297.8 мянган иргэдийн тэтгэвэрт 81.4 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 74.1 хувь буюу 60.3 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 208.2 мянган иргэнд зарцуулсан байна.

Тэтгэмжийн даатгалын сан

Тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 11.0 мянган иргэнд 3.6 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт 70.1 хувь буюу 2.5 тэрбум төгрөгийг жирэмсний болон амаржсаны тэтгэмжид зарцуулжээ.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 6-р сард 7.3 мянган тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын тэтгэвэрт 2.7 тэрбум төгрөг, 93 хүнд хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 124.8 сая төгрөгийг тус тус зарцуулав. Сангийн зардал өмнөх оны мөн үеэс 1.4 дүдәәтөгрөгөөр нэмэгдсэн байна.


Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын сангаас 692 хүнд 512.4 сая төгрөгийг ажилгүйдлийн даатгалын тэтгэмж, сургалтын зардалд зарцуулсан нь 2011 оны мөн үетэй харьцуулахад 64.4 сая төгрөгөөр буурчээ

Эрүүл мэндийн даатгалын сан

Тухайн сард эрүүл мэндийн даатгалын сангаас эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан 373.1 мянган хүний зардалд 10.0 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт зардлын 93.5 хувийг эмнэлгийн тусламж үйлчилгээний зардалд, 2.1 хувийг рашаан сувилалд, 4.3 хувийг эмийн үнийн хөнгөлөлтөд тус тус зарцуулав.

Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /Тэрбум төгрөгөөр/



ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /Сая төгрөгөөр/

	2011_6 сар	2012_6 сар	Зөрүү
Тахир дутуугийн	1,301.1	2,485.1	1,184.0
Тэжээгчээ алдсаны	76.1	238.9	162.8
Тэтгэмж, төлбөрийн	68.3	48.9	- 19.5
Сувиллын	21.4	75.9	54.5
Нийт дүн	1,466.9	2,848.8	1,381.9

Ажилгүйдлийн даатгалын сангийн зарлага /Сая төгрөгөөр/

	2011_6 сар	2012_6 сар	Зөрүү
Ажилгүйдлийн тэтгэмж	575.4	512.4	- 63.0
Сургалтын зардал	1.4	-	- 1.4
Нийт дүн	576.8	512.4	- 64.4

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага /Сая төгрөгөөр/

	2011_6 сар	2012_6 сар	Зөрүү
Эмнэлгийн эмчилгээний зардал	7,486.4	9,958.2	2,471.8
Рашаан сувиллын зардал	175.8	228.7	52.8
Эмийн үнийн хөнгөлөлт	306.5	461.4	154.9
Нийт дүн	7,968.7	10,648.3	2,679.6


Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 19.3 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 93,2 хувь буюу 18,0 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Нийт авлагын 42,5 хувийг 121 ба түүнээс хоногтой хуримтлагдсан авлагын эзэлж байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардал

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд нийт 8312,8 сая төгрөг төлөвлөснөөс 6971,8 сая төгрөг зарцуулж, 1341,0 сая төгрөг хэмнэгдсэн байна. Уг зардал нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 125,5% буюу 1415,2 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Нийгмийн даатгалын шимтгэлийн 5 дугаар сарын авлага /сая төгрөгөөр/



Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/

	2011_6 сар	2012_6 сар	Өөрчлөлт	
			Тоогоор	Хувиар
Цалингийн сан, нийгмийн даатгалын шимтгэл	4103,3	5698,8	1595,5	138,8%
Бараа үйлчилгээний бусад зардал	1453,3	1273,0	-180,3	87,6
Дүн	5556,6	6971,8	1415,2	125,5%